



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2019 онд Ирээдүйн өв санд Төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн
237 дугаар тогтоолын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
2019 ОНД ИРЭЭДҮЙН ӨВ САНД ТӨВЛӨРҮҮЛЭХ НОГДОЛ АШГИЙН ТООЦОО

№	Хуулийн этгээдийн нэр	Төрийн өмчийн оролцооны хувь	2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцлийн дүн		
			Цэвэр ашиг	Тооцох хувь	Тооцсон ногдол ашиг /төгрөгөөр/
1	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ	100	439,858,091,843.00	34.1	150,000,000,000.00
2	"Монголросцветмет" ТӨҮГ	100	7,842,831,381.38	20	1,568,566,276.28
	<i>Ирээдүйн өв санд төвлөрүүлэх нийт дүн</i>		447,700,923,224.38		151,568,566,276.28